



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

᠒᠐᠒4 оны ᠒᠘ сарын ᠒᠘ өдөр

Дугаар ᠗᠒᠐᠑

Улаанбаатар хот

Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан “Цэргийн бүртгэл явуулах журам”, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1378 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн хэмжээнд бэлтгэл офицер, ахлагч, цэргийн үүрэгтний бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 22-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт, тоон болон нэрийн бүртгэлийг дүүргийн 1, 2 дугаар хорооны ажлын албаны байранд тус тус зохион байгуулсугай.

2.Бүртгэлийн ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавьж ажиллах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: Л.Санжийжамц

Орлогч дарга: Ш.Бат-Өлзий

Гишүүд: Т.Лхагвасүрэн

М.Уранцэцэг

Н.Нямзав

Б.Батзориг

Нарийн бичиг: А.Баярбат

Засаг даргын Тамгын газрын дарга

Засаг даргын Тамгын газрын

Цэргийн штабын дарга, хурандаа

Цагдаагийн хэлтсийн дарга,

Цагдаагийн хурандаа

Улсын Бүртгэлийн хэлтсийн дарга

1 дүгээр хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

Засаг даргын Тамгын газрын

Цэргийн штабын Тоо бүртгэл,

дайчилгааны ахлах офицер, дэд

хурандаа

3.Цэргийн бүртгэлийг зохион байгуулах Ажлын хэсэгт:

3.1.Цэргийн бүртгэлийн ажлыг тогтоосон хугацаанд хороодын хүн амын бүртгэлийн сан, Цэргийн бүртгэлийн мэдээллийн сантай тулгалт хийж явуулах, гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоон, бүртгэл явуулахад шаардлагатай автомашин, ажлын байр, хүн хүчийг ажлын хэсгийн даргын тушаалаар баталж ажиллуулах.

3.2.Цэргийн бүртгэлийг Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан “Цэргийн бүртгэл явуулах журам”-ыг үндэслэн Засаг захиргааны анхан шатны нэгж, хорооны Засаг даргын ажлын байранд цаасан суурьтайгаар, тоон бүртгэлийг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia системийн хамт Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт зохион байгуулан ажиллах.

АЖЛ/2024 он ажил/захирамж

1123200552

3.3.Бүртгэлийг эрхлэн гүйцэтгэх албан тушаалтнуудад холбогдох хууль, тогтоомж "Цэргийн бүртгэлийг зохион байгуулах журам", Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia системийн талаарх мэдээллийг олгох сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж шаардлагатай гарын авлага, бүртгэлийн материалаар ханган, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажиллах.

3.4.Цэргийн бүртгэлтэй холбогдуулан ард иргэд, цэргийн жинхэнэ болон бэлтгэл үүрэгтнүүдэд "Цэргийн албаны тухай хууль", бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулж явуулах.

3.5.Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдад байгууллагын хаягаар зар мэдээлэл, мэдэгдэл, албан тоот хүргүүлэн хяналтын бүртгэл явуулж, бүртгэлд хамрагдсан бусад аймаг, сум, дүүргүүдийн иргэдийн нэрийн жагсаалтыг харьяа орон нутгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлэх ажлыг зохион байгуулах.

3.6.Дүүргийн Цагдаагийн хэлтсийн бүртгэлээс зэвсэг эзэмшигчдийн бүртгэлийг гаргуулан авч мэдээллийг бүртгэлийн санд оруулах, бүртгэлээс зайлсхийгчид, завсардагчдыг эрэн сурвалжилж, бүртгэлд хамруулах ажилд, Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтнууд болон хороодын нийгмийн ажилтан хэсгийн ахлагч нарыг татан оролцуулж, Цэргийн бүртгэлийн журам зөрчигчдөд хуулийн дагуу хариуцлага тооцон ажиллах.

3.7.Хороодод явагдаж буй цэргийн бүртгэлийн ажлын явцад төрийн захиргааны байгууллагын хэлтэс, албадын дарга нарыг томилгоожуулан хуваарийн дагуу шалган туслах ажлыг гүйцэтгүүлэх.

3.8.Цэргийн бүртгэлийн явцын мэдээг тухай бүрд нь танилцуулж, бүртгэлийг зохион байгуулсан тухай тайлан, мэдээ судалгааг нийслэлийн Засаг даргын захирамжид заасан хугацаанд холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэх.

4.Хороодын Засаг дарга нарт даалгах нь:

4.1.Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицер, ахлагч нарын бүртгэлийг хорооны хүн ам, өрхийн мэдээллийн сан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний бүртгэлийн системтэй тулган тогтоосон хугацаанд төрийн болон албаны, хувь хүний нууц хадгалалт, хамгаалалтыг хууль, тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулах.

4.2.Цар тахлын үеийн халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиулж хүн хоорондын зай барих, дэлхий эрүүл мэндийн байгууллага, Улс, нийслэл, дүүргийн, Онцгой комиссоос гаргасан зөвлөмж удирдамжийг сахин хамгаалж, ажилтан албан хаагчдын ажлын болон амралт (цайны) цагийг зохицуулан ажиллуулах.

4.3.Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын бүртгэлийн ажлыг зохион байгуулахдаа маягт №1 (дэлгэрэнгүй бүртгэл), маягт №4 (Цэргийн жинхэнэ албанд татагдагчийн анкет), маягт №12 (тооцооны хуудас), маягт №6 (бэлтгэл офицерийн маягт)-уудыг бүрэн, үнэн зөв хөтөлж, 1975-2007 онд төрсөн байнгын оршин суугч эрэгтэйчүүд, оюутнуудыг хороогоор, түр оршин суугч ажилчин, алба хаагчдыг ажлын газрын хаягаар бүртгэлд хамруулан бүртгэлийн мэдээг өдөр бүр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт тогтоосон хугацаанд нь өгч байх.

4.4.Цэргийн алба хаагаагүй хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн судалгааг гарган Цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчлан таниулж иргэний үүргээ биелүүлэх талаар мэдээлэл өгч ажиллах.

4.5.Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицерийн бүртгэл явуулсан тухай дүн, тайлан мэдээ, түүнтэй уялдуулан гаргадаг бусад мэдээ судалгааг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17:00 цагт Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ирүүлэхийг тус тус үүрэг болгосвгай.

4.6.Цэргийн бүртгэлд 2025 онд 18 нас хүрэх иргэнийг харьяа хороонд нь биечлэн ирүүлж бүртгэлд хамруулах.

5.Цэргийн бүртгэлийг явуулахад шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталж, үйл ажиллагаанд зарцуулагдах 2.678.200 (Хоёр сая, зургаан зуун далан найман мянга, хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

6.Хороодыг цэргийн мэргэжлийн удирдлагаар ханган өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, бүртгэлийн явц, чанар, цэргийн үүрэгтнүүдийн хамралтад байнга хяналт тавьж, дүнг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний дотор танилцуулахыг Цэргийн штаб (хурандаа Ш.Бат-Өлзий)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

7.Үйл ажиллагааг зохион байгуулж дууссанаас хойш 5 хоногийн дотор санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 12 дугаар сарын 12 ны өдрийн
1809 дугаар захирамжийн хавсралт

2025 ОНЫ ЦЭРГИЙН ҮҮРЭГТЭН БЭЛТГЭЛ
ОФИЦЕРУУДЫН БҮРТГЭЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

д/д	Хэрэгжих ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хорооны бүртгэлийн хаяг анонс, эх бэлтгэлийн үнэ	1.5x2=3м ² Х3ш	25.800	232.200
2	Цэргийн бүртгэлийн баннер	4x5=20м ²	250.000	250.000
3	1а маягт	50	300	60.000
4	1б маягт	50	300	
5	1в маягт	50	300	
6	1г маягт	50	300	
7	2а маягт	50	300	60.000
8	2б маягт	50	300	
9	2в маягт	50	300	
10	2г маягт	50	300	
11	Зөрчлийн мэдэгдэх хуудас	100	300	30.000
12	Цэргийн албанд татагдагчдын анкет 4-р маягт	200	300	60.000
13	Бэлтгэл үүрэгтний Тооцооны хуудас 12-р маягт	400	300	120.000
14	Бэлтгэл офицер, ахлагчийн карт	60	300	18.000
15	Сурталчилгааны хуудас (том) А-2	20	10.000	200.000
16	Сурталчилгааны хуудас (дунд) А-3	30	8000	240.000
17	Сурталчилгааны хуудас (жижиг) А-4	10	6000	60.000
18	6 ком вирусын программ	3 cd	187000	561.000
19	Хэсгийн ахлагч нарын холбооны зардал	6	20.000	120.000
20	Дардасны улаан тос	3	8000	24000
Нийт				2.035.200
Цэргийн бүртгэлд 18 хүрсэн хүүхэд, залуучуудад “Эх оронч хүмүүжил”-ээр багш урьж лекц яриа хийлгэх, цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулах				
21	Батламж	20	8000	160.000
22	Цэргийн үүрэгтний үнэмлэх	20	3000	60.000
23	Багшийн нэг удаагийн цалин хөлс	1	150.000	150.000
Нийт				370.000

Зарцуулах шатахуун				
24	Алсын хэсэг өртөө зөрлөгт ажиллах	60л	1950	117000
25	Явцын мэдээ (ЗХЖШ, Нийслэл) 2 удаа	40 л	1950	78000
26	Шалгалтын туслах ажлын явуулах үеийн	20л	1950	39000
27	Нэгдсэн хурал, дүн мэдээ хүргэх	20л	1950	39000
				273.000
Нийт				2.678.200